



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/653

Хэрлэн сум

Хяналт шалгалтын  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын нутаг дэвсгэрт Баян уул нэртэй XV-020014 дугаар бүхий ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Буянтпрокюрмент” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:	Б.Дарханбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичиг:	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
Гишүүд:	Ө.Маналжав	Мэргэжлийн хяналтын газрын Уул уурхайн хяналтын улсын байцаагч
	Д.Буянбат	Хэрлэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Э.Амарсайхан	Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

2.Хяналт шалгалтын ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, үр дүнг дүгнэж, санал зөвлөмжийн хамт 2022 оны 12 дугаар сарын 27-ны дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /Б.Дарханбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ